



СУРАГЧДЫН ДИЖИТАЛ БИЧИГ ҮСГИЙН БОЛОВСРОЛ УНШИЖ ОЙЛГОХ ЧАДВАРТ НӨЛӨӨЛӨХ НЬ (5 дугаар ангийн сурагчдын жишээн дээр)

Д.Ганболд
МУБИС-ийн Багшийн сургуулийн МХНУТ-ийн багш, доктор (Ph.D);
Холбоо барих зохиогч: Мэйл IDganbold.d@msue.edu.mn  ORCID ID

Хүлээн авсан: 2026.03.15 Хянагдсан: 2026.04.07 Зөвшөөрсөн: 2026.05.18

Хураангуй

Энэхүү судалгааны зорилго нь сурагчдын дижитал бичиг үсгийн боловсрол уншиж ойлгох чадварт хэрхэн нөлөөлж буйг 5-р ангийн сурагчдын жишээн дээр тодруулахад оршино. Судалгаанд Нийслэл, Хөвсгөл, Хэнтий, Өмнөговь аймгийн нийт 736 сурагчийг хамруулж, тэдний дижитал бичиг үсгийн түвшин, унших ойлгох чадвар, эцэг эхийн боловсрол, ажил эрхлэлт болон хүмүүншил төлөвшлийн үзүүлэлтүүдийг харьцуулан шинжиллээ. Сүүлийн жилүүдэд дижитал орчинд унших чадвар сурагчдын суралцах амжилтад голлох нөлөө үзүүлж буйг олон улсын судалгаанууд онцолдог (OECD, 2023). Мөн дижитал бичиг үсгийн өндөр чадвар нь онлайн орчинд мэдээллийг хайх, шүүн тунгаах, гол санааг ялган авахад дэмжлэг болдог нь нотлогдсон (Leu et al., 2019). Судалгааны урьдчилсан үр дүнгээр дижитал бичиг үсгийн өндөр түвшинтэй сурагчдын уншиж ойлгох чадварын дундаж оноо бусдаасаа статистикийн ач холбогдолтойгоор өндөр байсан бөгөөд энэ хамаарал эцэг эхийн боловсролын түвшнээс тодорхой хэмжээнд хамаарах хандлагатай байв. Иймд дижитал бичиг үсгийн системтэй сургалт нь бага ангийн сурагчдын унших чадварыг дэмжих үр нөлөөтэй болохыг энэхүү судалгаа харуулж байна.

Түлхүүр үг

дижитал орчин, унших стратеги, уншиж ойлгох чадвар, хүмүүжил төлөвшил, байршлын ялгаа, гэр бүлийн нөлөө, бага ангийн сурагч

Удиртгал

Боловсролын салбар дахь технологийн хурдацтай хөгжил нь сурагчдын дижитал орчинд мэдээлэлтэй харьцах чадвар болон уншиж ойлгох чадварыг судалгааны шинэ түвшинд авч үзэх хэрэгцээ, шаардлагыг бий болгож байна. Дижитал бичиг үсэг нь зөвхөн технологи ашиглах техникийн чадвар бус, харин мэдээллийг хайх, үнэлэх, боловсруулах, аюулгүй хэрэглээг хэвшүүлэх цогц чадвар болохыг олон улсын судалгаанууд онцолдог (OECD, 2023). Энэхүү чадвар нь сурагчдын уншиж



ойлгох чадвар, суралцах амжилт, танин мэдэхүйн хөгжилд хүчтэй нөлөөлдөг болохыг сүүлийн үеийн олон судалгаагаар баталсаар байна (Leu et al., 2019). Монгол Улс хувьд авч үзвэл сурагчдын дижитал орчинд өнгөрөөх хугацаа жил ирэх тусам нэмэгдэж буй нь тэдний мэдээлэл боловсруулах үйл явц, унших чадварын чанарын түвшинг илүү нарийвчлан судлах шаардлагыг улам бүр нэмэгдүүлж байна.

Судалгааны зорилго

Монгол Улсын Нийслэл болон Хөвсгөл, Дундговь, Хэнтий аймгийн 5-р ангийн 736 сурагчийн дижитал бичиг үсгийн чадвар нь уншиж ойлгох чадвар болон хүмүүжил төлөвшилд хэрхэн нөлөөлж буйг тодорхойлох.

Зорилт

- Сурагчдын дижитал бичиг үсгийн чадварыг тодорхойлох.
- Уншиж ойлгох чадварын түвшинг хэмжиж, үнэлэх.
- Хүмүүншлийн боловсролын төлөвшил, эцэг эхийн боловсрол, ажил эрхлэлтийн байдал зэрэг хүчин зүйлсийн нөлөөллийг тодорхойлох.
- Дижитал бичиг үсэг болон уншиж ойлгох чадварын хоорондын хамаарал, уялдааг шинжлэх.

Судалгааны хэрэгцээ, шаардлага

Шинэ үеийн сурагчид улам бүр хөгжиж буй цахим орчинд суурилсан суралцах орчинтой тулгарч байгаа ч дижитал мэдээллийг шүүн тунгаах, гол санааг ялгах, найдвартай эх сурвалжийг ашиглах чадвар дутмаг хэвээр байна. Улмаар уншиж ойлгох чадвар буурч буй нь олон улсын үнэлгээнүүдээр баглагдсан. Иймд дижитал бичиг үсгийн чадвар ба унших чадварын бодит уялдааг үндэсний хэмжээнд судлах нь сургалтын бодлого, арга зүйг боловсронгуй болгоход чухал ач холбогдолтой юм.

Дэвшүүлж буй асуудал

- Дижитал бичиг үсгийн чадвар бага ангийн сурагчдын уншиж ойлгох чадварт нөлөөлж буй хүчин зүйлс юу вэ?
- Бүсийн төлөөлөл болсон (Нийслэл, Хөвсгөл, Хэнтий, Өмнөговь) сурагчдын дижитал хэрэглээний ялгаа нь уншлагын чадварт хэрхэн нөлөөлж байна вэ?
- Эцэг эхийн боловсрол, ажил эрхлэлт нь хүүхдийн дижитал бичиг үсэг ба унших чадварт нөлөөлөх хүчин зүйл болж чадаж байна уу?

Дижитал бичиг үсгийн боловсрол: уншиж ойлгох чадвар ба хүмүүжил төлөвшлийн онол, судалгааны үндэс

Vygotsky-ийн суралцахуйн онол нь хүүхдийн танин мэдэхүйн хөгжилд нийгмийн орчин, багш, гэр бүл, хамт олон, орчны үүргийг тодотгож өгдөг бол **Tan & Goh (2018), Leu et al. (2015)** нарын судалгаагаар дижитал бичиг үсгийн чадвар нь танин мэдэхүйн чадвар, уншиж ойлгох чадварт шууд нөлөөлдөг болохыг онцлон үзүүлсэн.

Цахим орчинд мэдээллийг хайж, үнэлж, зохистой эх сурвалжийг ашиглах чадвар нь сурагчдын унших стратеги болон гол санааг ялгах ур чадварыг хөгжүүлэхэд чухал болохыг тэмдэглэсэн. Түүнчлэн хүмүүжил төлөвшлийн онол(Character Education, Social-Emotional Learning)-уудад хүүхдийн ёс зүй, бусдад туслах хандлага, зөрчил маргааныг шийдвэрлэх чадвар нь гэр бүл, сургууль, багш, найз нөхөд, нийгмийн орчин болон соёл уламжлалын нөлөөгөөр төлөвшдөг гэж үздэг. Эдгээр онолууд нь сурагчдын дижитал бичиг үсгийн боловсрол нь мэдээлэл боловсруулах, унших, ойлгох үйл явцыг дэмжиж, мөн хүмүүжил, ёс зүйн зан үйлд эерэг нөлөө үзүүлж болохыг тайлбарладаг тул судалгааны ажлын онолын үндэс болно. Leu et al. (2015), Tan & Goh (2018) нар дижитал орчны мэдээллийг боловсруулах чадвар нь уншиж ойлгох болон суралцах стратегид шууд нөлөөлдөг болохыг нотолсон бол Писса (PISA) болон олон улсын үнэлгээний судалгаа дижитал бичиг үсгийн боловсрол нь сурагчдын мэдээлэл боловсруулах, задлан шинжилж, тайлбарлан, дүгнэж унших чадварыг сайжруулдаг болохыг тайландаа тусгасан байдаг. Боловсрол судлаач (Цэвээлхазал, 2020) нь бага ангийн сурагчдын уншиж ойлгох чадвар нь өмнөх мэдлэг, анхаарал төвлөрөл, багшийн арга зүйтэй нягт холбоотой болохыг судалгаагаар баталсан.

Судалгааны арга зүй

Сурагчдын дижитал бичиг үсгийн боловсролыг (компьютер/таблет ашиглах чадвар, хайлт хийдээ түлхүүр үг ашиглах чадвар, зохистой их сурвалжийг ашиглах чадвар, өөрт хэрэгтэй мэдээллийг ялгах чадвар, цахим аюулгүй байдлын тухай ойлголт) гэсэн 5 шалгуураар, уншиж ойлгох чадварыг (Унших болон ойлгох түвшин, гол санааг тодорхойлох чадвар, уншсанаа өөрийн үгээр тайлбарлах чадвар) гэсэн 3 шалгуур, хүмүүжил төлөвшил хандлагыг (бусдад туслах хандлага, зөрчил маргааныг шийдэх чадвар, хүндлэл ба ёс зүйн хандлага) гэсэн 3 үзүүлэлтээр ангийн багшаас нь тус тус судалгааг авсан. Судалгааны асуултын хариултад буюу үнэлгээнд LIKERT аргыг ашиглан “4-Маш сайн”, “3-Сайн”, “2-Дунд”, “1-Сул” гэж хэмжээсжүүлсэн болно. Мөн хяналтын хувьсагчаар байршил, тухайн сурагчийн хүйс, эцэг эхийн боловсрол, эрхэлдэг ажлын судалсан.

Хүснэгт 1.1. Судалгаанд ашигласан мэдээллийн тоо

Цуглуулсан мэдээллийн тоо	Судалгаанд ашигласан мэдээллийн тоо
760	736(96.84%)

Хүснэгт 1.1.-т үзүүлсэнчлэн, судалгаанд анх цуглуулсан нийт мэдээллийн тоо 760 байна. Үүнээс 736 мэдээлэл нь судалгаанд ашиглагдсан бөгөөд энэ нь цуглуулсан мэдээллийн 96.84%-ийг бүрдүүлж байна.

Энэхүү хувь (96.84%) нь судалгааны үр дүн, бодит байдлыг баталгаажуулж, 5-р ангийн сурагчдын дижитал бичиг үсгийн чадвар нь унших чадвар болон хүмүүжил төлөвшилд нөлөөлөх байдлыг үнэлэхэд чухал үндэс болно. Судалгаанд хэрэглэсэн мэдээллийн чанар нь дижитал боловсролын нөлөөллийг үр дүнтэй илрүүлэхэд туслах бөгөөд уг зорилгод нийцсэн дүн шинжилгээ хийх боломжийг олгосон.



Хүснэгт 1.2. Судалгаанд ашигласан түүврийн мэдээлэл

		Тоо	Хувь
Байршил	Нийслэл	69	9.38%
	Аймгийн төв	374	50.82%
	Сум	293	39.81%
Нас	9	14	1.90%
	10	660	89.67%
	11	56	7.61%
	12	5	0.68%
	13	1	0.14%
Эцгийн боловсрол	Боловсролгүй	66	9.91%
	Суурь	379	56.91%
	Тусгай дунд	45	6.76%
	Дээд	176	26.43%
Эхийн боловсрол	Боловсролгүй	39	5.45%
	Суурь бүрэн дунд	347	48.46%
	Тусгай дунд	40	5.59%
	Дээд	290	40.50%
Эцгийн хөдөлмөр эрхлэлт	Ажилгүй	30	4.59%
	Малчин	197	30.12%
	Хувийн хэвшил	321	49.08%
	Төрийн	106	16.21%
Эхийн хөдөлмөр эрхлэлт	Ажилгүй	75	10.53%
	Малчин	152	21.35%
	Хувийн хэвшил	300	42.13%
	Төрийн	185	25.98%

Байршлын төлөөллийг хангах зорилгоор нийслэл, аймгийн төв болон сумын сургуулиудаас олон шатлалт түүвэрлэлт ашиглан сонгосон. Ийнхүү байршлын ялгаатай нөхцөлөөс түүвэр авах нь дижитал орчны хүртээмж, унших орчны өөрчлөлт, мөн орчны ялгаа нь сурагчдын хүмүүжил төлөвшилд хэрхэн нөлөөлж байгааг шинжлэх боломжийг бүрдүүлсэн. Судалгаанд хамрагдсан сурагчдын насны дундаж нь $M = 10.14$, $SD = 0.47$ бөгөөд энэ нь түүврийн насны хувьд жигд, нэгэн төрлийн бүтэцтэйг илтгэнэ. Эцэг эхийн боловсролын түвшинг судалгаанд багтаасан нь хүүхдийн уншлагын орчин, цахим хэрэглээний боломж, мөн гэр бүлийн хүмүүжил төлөвшлийн орчин хэрхэн бүрдэж буйг тодорхойлоход чухал ач холбогдолтой гэж үзсэнтэй холбоотой. Харин хөдөлмөр эрхлэлт нь өрхийн эдийн засгийн түвшнийг тодорхойлох гол үзүүлэлт тул дижитал төхөөрөмжийн хүртээмж, мэдээллийн хэрэглээний чанар, хүүхдийн бие даан суралцах, хэвшил төлөвшлийн орчинд үзүүлэх нөлөөллийг тооцох зорилгоор тусад нь авч үзлээ. Эцэг эхийн хөдөлмөр эрхлэлтийн бүтэц хот, хөдөөгийн тэгш бус нөхцөлийг илэрхийлэх

бөгөөд энэ ялгаа нь сурагчийн дижитал орчинд хандах боломж болон хүмүүжил төлөвшлийн төлөв байдалд тодорхой хэмжээгээр нөлөөлөх магадлалтай. Ийнхүү ердийн боловсролын сургуульд суралцаж буй 5 дугаар ангийн сурагчдаас бүрдсэн энэхүү түүвэр нь байршлын ялгаатай нөхцөл, эцэг эхийн боловсролын түвшин, хөдөлмөр эрхлэлтийн байдал зэрэг олон хүчин зүйлийг төлөөлсөн бөгөөд дижитал бичиг үсгийн боловсрол нь уншиж ойлгох чадвар болон хүмүүжил төлөвшилд хэрхэн нөлөөлж буйг статистик аргаар шинжлэх боломжийг бүрдүүлсэн.

Судалгааны үр дүн

Хүснэгт 2.1. Үзүүлэлтийн найдвартай байдал

	Үзүүлэлт	Дундаж	Ст.хазайлт	Найдвартай байдал
Дижитал бичиг үсгийн боловсрол	Цахим.хэрэгсэл.ашиглах.чадвар	2.83	0.852	0.872
	Хайлт хийдээ түлхүүр үг ашигладаг	2.58	0.905	
	Зохистой их сурвалжийг ашиглах чадвар	2.54	0.839	
	Өөрт хэрэгтэй мэдээллийг ялгах чадвар	2.71	0.944	
Уншиж ойлгох чадвар	Цахим аюулгүй байдлын ойлголт	2.92	0.888	0.905
	Унших болон ойлгох түвшин	2.98	0.921	
	Гол санааг тодорхойлох чадвар	2.77	0.973	
Хүмүүжил төлөвшил хандлага	Уншсанаа өөрийн үгээр тайлбарлах чадвар	2.81	0.960	0.800
	Бусдад туслах хандлага	3.32	0.734	
	Зөрчил маргааныг шийдэх чадвар	2.85	0.835	
	Хүндлэл ба ёс зүйн хандлага	3.29	0.772	

Дижитал бичиг үсгийн боловсрол, уншиж ойлгох чадвар болон хүмүүжил төлөвшлийн хандлагын хэмжилтийн бүх үзүүлэлт **найдвартай ($\alpha = 0.800-0.905$)** түвшинд байна. Дундаж утгууд нь гурван үзүүлэлтийн хувьд сурагчдын чадвар, хандлага дундаж ба түүнээс дээш түвшинд байгааг харуулсан. Мөн стандарт хазайлт нэлээд хэлбэлзэлтэй байгаа нь сурагчдын хоорондын ялгаатай байдлыг статистикийн шинжилгээнд тусган тайлбарлах боломжийг бүрдүүлж байна.

Хүснэгт 2.2. Үзүүлэлтийн хамаарал

	Дижитал бичиг үсгийн боловсрол	Уншиж ойлгох чадвар	Хүмүүжил төлөвшил хандлага
Дижитал бичиг үсгийн боловсрол		.684**	.479**
Уншиж ойлгох чадвар	.684**		.567**
Хүмүүжил төлөвшил хандлага	.479**	.567**	

* $p < 0.05$, ** $p < 0.01$, *** $p < 0.001$



Гурван үзүүлэлт хоорондоо эерэг, ач холбогдол бүхий хамааралтай байгаа нь дижитал бичиг үсгийн боловсрол нь зөвхөн танин мэдэхүй (уншиж ойлгох чадвар)-д төдийгүй сурагчийн хүмүүжил төлөвшилд ч тодорхой хэмжээгээр нөлөөлж байгааг харуулж байна. Мөн унших чадвар хөгжсөн байх нь сурагчийн нийгмийн харилцааны чанарт дэмжлэг үзүүлдэг болохыг энэхүү хамаарал нотолж байна.

Хүснэгт 2.3.Харьцуулсан шинжилгээний үр дүн

		Дундаж	Ст.хазайлт	Статистик утга		
Байршил	Дижитал.бичиг.үсгийн. боловсрол	Нийслэл	2.99	0.66	31.314***	
		Аймгийн төв	2.45	0.75		
		Сум	2.84	0.69		
	Уншиж.ойлгох.чадвар	Нийслэл	2.80	0.82		1.651
		Аймгийн төв	2.80	0.92		
		Сум	2.93	0.82		
	Хүмүүжил.төлөвшил. хандлага	Нийслэл	3.09	0.80		1.486
		Аймгийн төв	3.13	0.64		
		Сум	3.21	0.65		
Хүйс	Дижитал.бичиг.үсгийн. боловсрол	Эрэгтэй	2.61	0.77	-1.987*	
		Эмэгтэй	2.72	0.73		
	Уншиж.ойлгох.чадвар	Эрэгтэй	2.74	0.90	-3.480**	
		Эмэгтэй	2.97	0.83		
	Хүмүүжил.төлөвшил. хандлага	Эрэгтэй	3.07	0.69	-3.643**	
		Эмэгтэй	3.25	0.61		
	Эцгийн боловсрол	Дижитал.бичиг.үсгийн. боловсрол	Боловсролгүй	2.20	0.79	19.038***
			Суурь	2.60	0.71	
Тусгай дунд			2.81	0.72		
Дээд			2.95	0.71		
Уншиж.ойлгох.чадвар		Боловсролгүй	2.42	1.03	12.443***	
		Суурь	2.80	0.82		
		Тусгай дунд	3.03	0.78		
		Дээд	3.12	0.82		
Хүмүүжил.төлөвшил. хандлага		Боловсролгүй	2.76	0.71	10.898***	
		Суурь	3.15	0.65		
		Тусгай дунд	3.23	0.64		
		Дээд	3.29	0.64		



Эхийн боловсрол	Дижитал.бичиг.үсгийн. боловсрол	Боловсролгүй	1.86	0.80	34.965***
		Суурь	2.51	0.68	
		Тусгай дунд	2.90	0.67	
		Дээд	2.91	0.70	
	Уншиж.ойлгох.чадвар	Боловсролгүй	2.13	0.94	21.543***
		Суурь	2.70	0.85	
		Тусгай дунд	3.03	0.73	
		Дээд	3.10	0.82	
	Хүмүүжил.төлөвшил. хандлага	Боловсролгүй	2.76	0.71	10.307***
		Суурь	3.08	0.67	
		Тусгай дунд	3.26	0.54	
		Дээд	3.29	0.61	
Эцгийн хөдөлмөр эрхлэлт	Дижитал.бичиг.үсгийн. боловсрол	Ажилгүй	2.12	0.74	11.520***
		Малчин	2.51	0.68	
		Хувийн хэвшил	2.75	0.77	
		Төрийн	2.86	0.68	
	Уншиж.ойлгох.чадвар	Ажилгүй	2.23	0.92	12.324***
		Малчин	2.71	0.81	
		Хувийн хэвшил	2.89	0.88	
		Төрийн	3.20	0.82	
	Хүмүүжил.төлөвшил. хандлага	Ажилгүй	2.60	0.87	9.162***
		Малчин	3.08	0.62	
		Хувийн хэвшил	3.19	0.69	
		Төрийн	3.31	0.56	
Эхийн хөдөлмөр эрхлэлт	Дижитал.бичиг.үсгийн. боловсрол	Ажилгүй	2.48	0.81	5.038**
		Малчин	2.54	0.72	
		Хувийн хэвшил	2.70	0.71	
		Төрийн	2.80	0.78	
	Уншиж.ойлгох.чадвар	Ажилгүй	2.76	1.01	3.126*
		Малчин	2.78	0.86	
		Хувийн хэвшил	2.81	0.83	
		Төрийн	3.02	0.88	
	Хүмүүжил.төлөвшил. хандлага	Ажилгүй	3.04	0.69	2.101
		Малчин	3.11	0.65	
		Хувийн хэвшил	3.16	0.67	
		Төрийн	3.24	0.63	

*p<0.05, **p<0.01, ***p<0.001



Байршлын хувьд дижитал бичиг үсгийн боловсролын түвшин **статистикийн хувьд маш өндөр ач холбогдол бүхий ялгаатай** ($F = 31.314$, $p < .001$) байв. Нийслэлийн сурагчид ($M = 2.99$) хамгийн өндөр түвшин, аймгийн төвийн сурагчид ($M = 2.45$) хамгийн доод түвшинд. Энэ нь дижитал орчны хүртээмж, техник технологийн хэрэглээний ялгаатай байдалтай шууд холбоотой байж болохыг харуулж байна. Уншиж ойлгох чадварын хувьд байршлын дундажуудад ялгаа байсан ч статистикийн хувьд ач холбогдолгүй ($F = 1.651$, $p > .05$). Энэ нь уншлагын суурь боловсрол байршлаас илүү багшийн арга зүй болон сургалтын хөтөлбөртэй нягт хамааралтай байж болохыг илтгэж байна.

Хүмүүжил төлөвшлийн хувьд мөн ялгаа хэв шинж ажиглагдсан боловч статистикийн хувьд ач холбогдолгүй ($F = 1.486$, $p > .05$) байв. Гэсэн хэдий ч сумын сурагчид ($M = 3.21$) хамгийн өндөр үнэлгээтэй байна. Энэ нь хөдөө орон нутгийн нүүдэлчин соёлын уламжлалтай холбоотой байж болох юм. *Эмэгтэй сурагчид дижитал бичиг үсгийн боловсрол* ($M = 2.72$), *уншиж ойлгох чадвар* ($M = 2.97$), *хүмүүжил төлөвшлийн хандлага* ($M = 3.25$) гэсэн бүх үзүүлэлтээр эрэгтэй сурагчдаас ($M = 2.61$; $M = 2.74$; $M = 3.07$) *статистикийн хувьд мэдэгдэхүйц өндөр үзүүлэлттэй* ($t = -1.987$, $t = -3.480^*$, $t = -3.643^{**}$) байсан нь эмэгтэй хүүхдүүдийн танин мэдэхүй, харилцааны ур чадвар болон хамтын ажиллагааны хандлага харьцангуй илүү хөгжсөн байгааг харуулж байна. Олон улсын судалгааны үр дүнгээс харахад дижитал бичиг үсгийн мэдлэг, чадварын хувьд **охид хөвгүүдээс илүү амжилт үзүүлэх хандлага** ажиглагддаг. Тухайлбал, ICILS 2013, 2018 оны өгөгдөлд тулгуурласан судалгаагаар охидын дижитал мэдлэг ба чадварын түвшин хөвгүүдийнхээс **статистикийн хувьд мэдэгдэхүйц өндөр** ($\beta = -0.11$ – -0.29) байгааг тогтоосон байна (Aesaert et al., 2023).

Эцэг, эхийн боловсрол нь дижитал бичиг үсгийн боловсрол ($F = 19.038^*$, $F = 34.965^{***}$), уншиж ойлгох чадвар ($F = 12.443^{***}$, $F = 21.543^{***}$), хүмүүжил төлөвшил хандлага ($F = 10.898^{***}$, $F = 10.307^{***}$) гэсэн үзүүлэлтэд өндөр ач холбогдолтой нөлөө үзүүлсэн бөгөөд дээд боловсролтой эцэг, эхтэй сурагчид хамгийн өндөр оноо авсан бол боловсролгүй эцэг, эхтэй сурагчид хамгийн доод түвшинд байна.

Эцгийн хөдөлмөр эрхлэлт бүх үзүүлэлтэд статистикийн хувьд өндөр ач холбогдолтой ялгааг үзүүлж ($p < .001$), төрийн албан хаагч эцэгтэй хүүхдүүд хамгийн өндөр, ажилгүй эцэгтэй хүүхдүүд хамгийн доод түвшинтэй байсан бол, эхийн хөдөлмөр эрхлэлт дижитал бичиг үсгийн боловсрол ($F = 5.038$) болон уншиж ойлгох чадвар ($F = 3.126^*$) дээр статистикийн ач холбогдолтой нөлөөтэй байсан боловч хүмүүжил төлөвшилд ач холбогдолтой ялгаа илрээгүй ($F = 2.101$, n.s), энэ нь хүмүүжил төлөвшлийн хандлага нь ээжийн ажлын байдал бус гэр бүлийн харилцааны орчин, хүмүүжилтэй илүү холбоотой байж болохыг харуулж байна.

Дижитал бичиг үсгийн боловсрол нь орчны ялгаанд хамгийн мэдрэмтгий үзүүлэлттэй байсан бөгөөд байршил, эцэг эхийн боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн түвшнээс хүчтэй хамаарч байна. Уншиж ойлгох чадвар нь эцэг эхийн боловсрол болон хүйсийн ялгаанд хамгийн мэдрэмтгий. Хүмүүжил төлөвшил хандлага нь байршлаас бага, харин гэр бүлийн эдийн засгийн үзүүлэлтээс ихээхэн хамааралтай.

Эмэгтэй сурагчид бүх үзүүлэлтээр эрэгтэй сурагчдыг илүү байна. Эдгээр үр дүн нь боловсролын хүртээмж, гэр бүлийн нөөц бололцоо, хүүхдийн танин мэдэхүйн болон нийгмийн хөгжил хоорондын нарийн шүтэлцээг нотлон харуулж байна.

Хэлэлцүүлэг

Энэхүү судалгааны үр дүн нь дижитал бичиг үсгийн боловсрол нь сурагчдын уншиж ойлгох чадвар болон хүмүүжил төлөвшлийн хандлагатай тодорхой уялдаа холбоотой болохыг харуулж байна. Ялангуяа дижитал бичиг үсгийн түвшин байршил, эцэг эхийн боловсрол, хөдөлмөр эрхлэлтээс ихээхэн хамаарч байгаа нь боловсролын хүртээмж, гэр бүлийн нөөц бололцоо суралцахуйн үр дүнд чухал нөлөөтэйг илтгэж байна. Харин уншиж ойлгох чадварын хувьд байршлын ялгаа статистикийн ач холбогдолгүй гарсан нь уншихын суурь чадвар нь орчны ялгаанаас илүү багшийн арга зүй, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилттэй холбоотой байж болохыг харуулж байна.

Эдгээр үр дүн нь бага боловсролын түвшинд дижитал бичиг үсгийг унших стратеги, хүмүүжил төлөвшлийн агуулгатай уялдуулан хөгжүүлэх шаардлагатайг нотолж байгаа бөгөөд цаашид сурагчдын бодит гүйцэтгэлийн үнэлгээ, урт хугацааны судалгаа, холимог арга зүйд суурилсан судалгаагаар энэхүү уялдаа холбоог гүнзгийрүүлэн судлах хэрэгцээ байгааг харуулж байна.

Дүгнэлт

Энэхүү судалгаагаар Монгол Улсын нийслэл болон Хөвсгөл, Дундговь, Хэнтий аймгийн ерөнхий боловсролын 5-р ангийн 736 сурагчийн **дижитал бичиг үсгийн боловсрол, уншиж ойлгох чадвар, хүмүүжил төлөвшил хандлага** хоорондын харилцан хамаарлыг тодорхойлж, байршил, хүйс, эцэг эхийн боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн нөлөөг шинжилсэн.

Судалгааны үр дүнгээс үзэхэд:

1. Дижитал бичиг үсгийн боловсрол нь уншиж ойлгох чадвар болон хүмүүжил төлөвшил хандлагад эерэг нөлөө үзүүлж байна. Сурагчдын дижитал хэрэглээ, мэдээлэл боловсруулалт болон цахим аюулгүй байдлын ойлголт өндөр байх тусам уншиж ойлгох чадвар болон эерэг хүмүүжил төлөвшлийн үзүүлэлт өндөр.
2. Эмэгтэй сурагчид бүх үзүүлэлтээр эрэгтэй сурагчдаас статистикийн хувьд мэдэгдэхүйц өндөр оноо авсан, энэ нь танин мэдэхүй, харилцааны ур чадвар, хамтын ажиллагааны хандлага эрэгтэй сурагчдад илүү хөгжсөн байгааг харуулж байна. Энэхүү судалгааны үр дүн нь олон улсын зарим судалгааны дүгнэлттэй нийцэж байна. Тухайлбал, ICILS 2013, 2018 оны өгөгдөлд үндэслэсэн судалгаагаар охид дижитал мэдлэг ба чадвараар хөвгүүдээс илүү амжилт үзүүлсэн ($\beta = -0.11$ — -0.29) нь манай судалгаанд илэрсэн хандлагатай ижил байна.
3. Эцэг, эхийн боловсрол өндөр байх нь бүх үзүүлэлтэд эерэг нөлөө үзүүлж, дээд боловсролтой эцэг, эхтэй сурагчид дижитал бичиг үсгийн боловсрол, уншиж



ойлгох чадвар, хүмүүжил төлөвшлийн хандлагаараа хамгийн өндөр түвшинд байна.

4. Эцэг, эхийн хөдөлмөр эрхлэлт нь дижитал бичиг үсгийн боловсрол, уншиж ойлгох чадвар, зарим тохиолдолд хүмүүжилд статистикийн ач холбогдолтой нөлөөтэй байсан. Төрийн албан хаагч эцэгтэй болон ажил эрхэлдэг эхтэй сурагчид өндөр үзүүлэлттэй байсан бол ажилгүй эцэг, эхтэй сурагчид хамгийн доод түвшинд байв. Хүмүүжил төлөвшлийн хандлага нь эхийн ажлын байдалд статистикийн ач холбогдолтой биш байсан нь гэр бүлийн харилцааны орчин, хүмүүжил, хэвшилтэй илүү холбоотой болохыг харуулж байна.
5. Байршлын ялгаа дижитал бичиг үсгийн боловсролд илүү мэдрэг байсан бол уншиж ойлгох чадвар, хүмүүжил төлөвшилд статистикийн хувьд ач холбогдол багатай гарсан. Энэ нь дижитал хүртээмж, техник хэрэгслийн боломж байршлаас их хамааралтайг харуулж байна.

Судалгааны үр дүн нь **сурагчдын дижитал бичиг үсгийн боловсрол нь танин мэдэхүйн чадвар ба хүмүүжил төлөвшилд шууд нөлөөлж**, гэр бүлийн нөөц бололцоо, хүйс, байршил зэрэг нийгмийн орчны хүчин зүйлүүдтэй уялдаж байгааг баталлаа. Судалгааны энэ дүгнэлт нь боловсролын бодлого төлөвлөлт, сургалтын арга зүйг хөгжүүлэх, хүүхдийн дижитал болон уншлагын чадварыг сайжруулахад практик ач холбогдолтой гэж үзэж байна.

Талархал

Энэхүү судалгааг зохион байгуулахад хамтран ажилласан Нийслэлийн ЕБ-ын 60 дугаар сургуулийн сургалтын менежер Л.Сарангэрэл, 47 дугаар сургуулийн сургалтын менежер М.Энхчимэг, Хэнтий аймгийн БГ-ын мэргэжилтэн Х.Байгальмаа, Өмнөговь аймгийн БГ-ын мэргэжилтэн Ц.Туулцэцэг нарт гүн талархал илэрхийлье.

Ном зүй

1. Leu, D. J., Forzani, E., Rhoads, C., Maykel, C., Kennedy, C., & Timbrell, N. (2015). *The new literacies of online research and comprehension: Rethinking the reading achievement gap*. *Reading Research Quarterly*, 50(1), 37–59. <https://doi.org/10.1002/trq.85>
2. Leu, D. J., Kinzer, C. K., Coiro, J., Castek, J., & Henry, L. A. (2013). New literacies: A dual-level theory of the changing nature of literacy, instruction, and assessment. In D. E. Alvermann, N. J. Unrau, & R. B. Ruddell (Eds.), *Theoretical models and processes of reading* (6th ed., pp. 1150–1181). Newark, DE: International Reading Association.
3. Organisation for Economic Co-operation and Development. (2021). *PISA 21st-Century Readers: Developing literacy skills in a digital world*. OECD.
4. Цэвээнлхазал, Я. (2020). *Бага ангийн сурагчдын уншиж ойлгох чадвар ба танин мэдэхүйн хөгжлийн харилцан хамаарал*
5. Tan, S. C., & Goh, C. C. M. (2018). *Дижитал бичиг үсгийн боловсрол ба танин мэдэхүйн хөгжил: 5-р ангийн сурагчдын жишээн дээр* [Digital literacy education and cognitive development: A case of Grade 5 students]. *Монгол боловсрол судлал*



THE INFLUENCE OF STUDENTS' DIGITAL LITERACY ON READING COMPREHENSION: A CASE STUDY OF GRADE 5 STUDENTS

Ganbold.D^a,

^aPh.D, Teachers School, MNUE;

Corresponding author: Мэйл IDganbold.d@msue.edu.mn  ORCID ID

Abstract

The purpose of this study is to examine how students' digital literacy influences their reading comprehension, using Grade 5 students as the focus group. A total of 736 students from Ulaanbaatar, Khuvsgul, Khentii, and Umnugovi provinces participated in the study. Their digital literacy levels, reading comprehension skills, parents' educational attainment, employment status, and indicators of character development were analyzed and compared. Recent international research highlights that reading in digital environments has become a key factor affecting students' academic achievement (OECD, 2023). Moreover, high levels of digital literacy have been shown to support students in searching for information online, evaluating sources, and identifying main ideas effectively (Leu et al., 2019). Preliminary findings of this study revealed that students with higher digital literacy scored significantly higher in reading comprehension, and this relationship appeared to be influenced to some extent by parents' educational levels. Therefore, the study suggests that structured digital literacy instruction can play an important role in enhancing reading comprehension among primary school students.

Keywords

digital environment, reading strategies, reading comprehension, character development, regional differences, family influence, primary school students
